



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/13/НА-СТА-ОНА

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Баруун-Урт хот  
2023 он

Дарга,  
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа  
Утас: 70518396  
Аудитын менежер: Г.Даваа  
Утас: 70512123  
Аудитор: О.Барчидгүнсэн  
Утас: 70512123

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
5.1 Албан шаардлага .....	12
5.2 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.03.28 № 157  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХАЙЛААСТ  
ГОЛОМТ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.СОДНОМЦЭРЭН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сумын засаг дарга Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын захиралтай 2020 онд гэрээ байгуулж, үүргийн биелэлтийг дүгнэн ашигтай ажиллуулсан нөхцөлд ашгийн 40 хувийн урамшуулал олгохоор заасан. Гэтэл гэрээний биелэлтийг дүгнээгүй, дүгнэх шалгуур үзүүлэлт хангалтгүй, 2021 оны санхүүгийн тайлангаар эдийн засгийн үзүүлэлтээр 98,482.0 мянган төгрөгийн авлага, 36,591.9 мянган төгрөг өр төлбөртэй байхад цэвэр ашгийн 30 хувиар буюу 10,040.1 мянган төгрөгийн урамшуулал олгожээ

#### Аудитын гол асуудал

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаар өмнөх онуудад үүссэн авлага 27,363.8 мянган төгрөгийг барагдуулах шаардлагатай байна.

#### Бусад асуудлын хэсэг

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулсан бөгөөд гэрээний биелэлтийг дүгнээгүй, дүгнэх шалгуур үзүүлэлт хангалтгүй.

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>195,639,420.46</b>	<b>175,842,927.12</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>78,456,596.53</b>	<b>71,947,457.26</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>78,456,596.53</b>	<b>71,947,457.26</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>78,456,596.53</b>	<b>71,947,457.26</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	78,456,596.53	71,947,457.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>99,383,940.70</b>	<b>41,178,402.19</b>
33401	Дансны авлага /ТӨҮГ/	74,505,378.16	15,189,059.50
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	901,809.99	3,606,390.14
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>23,976,752.55</b>	<b>22,382,952.55</b>
33510	Байгууллагаас авах авлага	4,986,781.46	4,986,781.46
33520	Хувь хүмүүсээс авах авлага	18,989,971.09	17,396,171.09
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0</b>	<b>84,259.02</b>
34600	Урьдчилж гарсан зардал	0	84,259.02
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>17,798,883.23</b>	<b>62,632,808.65</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>17,798,883.23</b>	<b>62,632,808.65</b>
35420	Аж ахуйн материал	2,099,341.87	998,789.27
35430	Сэлбэг хэрэгсэл	453,650.00	1,580,831.82
35440	Түлш, шатах тослох материал	15,245,891.36	60,053,187.56
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,642,673,498.04</b>	<b>1,614,057,535.62</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,642,673,498.04</b>	<b>1,614,057,535.62</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,621,494,298.04</b>	<b>1,592,878,335.62</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,332,077,173.37	1,351,157,173.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,192,058.70	-60,863,616.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,500,000.00	193,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,612,500.00	-20,262,500.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	427,962,715.00	427,962,715.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-213,867,521.03	-313,530,782.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,914,700.00	11,532,881.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,727,799.60	-7,829,851.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,439,589.00	11,712,316.27
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>21,179,200.00</b>	<b>21,179,200.00</b>
39301	Програм хангамж	21,679,200.00	21,679,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,838,312,918.50</b>	<b>1,789,900,462.74</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,324,176,123.69</b>	<b>1,273,170,959.72</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,324,176,123.69</b>	<b>1,273,170,959.72</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>36,937,134.55</b>	<b>16,752,354.92</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>36,937,134.45</b>	<b>16,752,354.92</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	27,026,469.37	13,253,502.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	301,302.68	0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	9,264,267.39	3,498,852.15
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	345,095.01	0
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>1,287,238,989.14</b>	<b>1,256,418,604.80</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,287,238,989.14	1,256,418,604.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>514,136,794.81</b>	<b>516,729,503.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>514,136,794.81</b>	<b>516,729,503.02</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	559,377,218.00	559,377,218.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	559,377,218.00	559,377,218.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-95,586,735.19</b>	<b>-92,994,026.98</b>

51210	Өмнөх үеийн үр дүн	-132,772,445.13	-95,586,735.20
51220	Тайлант үеийн үр дүн	37,185,709.94	2,592,708.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,346,312.00	50,346,312.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,838,312,918.50</b>	<b>1,789,900,462.74</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>104,110,031.68</b>	<b>108,393,021.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>104,110,031.68</b>	<b>108,393,021.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>104,110,031.68</b>	<b>108,393,021.27</b>
120009	Бусад орлого	48,472,967.94	128,561,422.56
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	268,289,809.09	262,336,214.91
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	221,100,233.93	287,116,557.30
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	8,447,488.58	4,611,941.10
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>66,924,321.74</b>	<b>105,800,313.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>66,924,321.74</b>	<b>105,800,313.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>66,924,321.74</b>	<b>105,800,313.05</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>65,678,851.74</b>	<b>105,800,313.05</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	59,822,576.50	104,880,488.82
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	1,724,529.70	458,630.12
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	4,131,745.54	461,194.11
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,245,470.00</b>	<b>0</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,245,470.00	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>37,185,709.94</b>	<b>2,592,708.22</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>37,185,709.94</b>	<b>2,592,708.22</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,311.96	-132,772,444.37	476,951,085.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,311.96	-132,772,444.37	476,951,085.59
9	Тайлант үеийн үр дүн	0	0	37,185,709.94	37,185,709.94
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.19	514,136,794.81
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.19	514,136,794.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-95,586,735.19	514,136,794.81
19	Тайлант үеийн үр дүн	0	0	2,592,708.22	2,592,708.22
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	559,377,218.00	50,346,312.00	-92,994,026.98	516,729,503.02

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>265,986,555.06</b>	<b>347,592,095.06</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>265,986,555.06</b>	<b>347,592,095.06</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>265,986,555.06</b>	<b>347,592,095.06</b>
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	265,986,555.06	347,592,095.06
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>258,795,268.55</b>	<b>356,665,781.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>258,795,268.55</b>	<b>356,665,781.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>258,795,268.55</b>	<b>356,665,781.32</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>64,743,477.00</b>	<b>70,467,303.80</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	64,743,477.00	70,467,303.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,161,185.72</b>	<b>31,265,309.50</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	27,161,185.72	31,265,309.50
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>104,848,012.17</b>	<b>172,630,872.80</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	80,255,396.00	75,957,568.17
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	24,592,616.17	96,673,304.63
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>62,042,593.66</b>	<b>82,302,295.22</b>
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	1,724,529.70	458,630.12
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	25,972,115.38	25,262,375.46
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	21,517,871.51	23,041,346.78
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	12,828,077.07	33,539,942.86
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>7,191,286.51</b>	<b>-9,073,686.26</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>7,902,739.72</b>	<b>5,744,546.99</b>
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	300,000.00	1,593,800.00
140007	Хүлээн авсан хүүний орлого	7,602,739.72	4,150,746.99
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>13,800,000.00</b>	<b>3,180,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,800,000.00</b>	<b>3,180,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,800,000.00</b>	<b>3,180,000.00</b>
225104	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	13,800,000.00	3,180,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-5,897,260.28</b>	<b>2,564,546.99</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-14,415,612.00</b>	<b>0</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>15,584,388.00</b>	<b>0</b>
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	15,584,388.00	0
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>30,000,000.00</b>	<b>0</b>
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	30,000,000.00	0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-13,121,585.77</b>	<b>-6,509,139.27</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,578,182.30	78,456,596.53
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,456,596.53	71,947,457.26

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	х.нэгж	2021 оны		2022 оны	
			Төлөвлөгөө	гүйцэтгэл	Төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		260,322.4	268,289.8	313,318.8	313,318.8

2	Нийт орлого	мян төг	260,322.4	268,289.8	313,318.8	313,318.8
3	Нийт зардал	мян төг	250,312.4	183,860.9	289,256.2	287,116.5
	Үүнээс: Удирдлагын зардал	мян төг	59,822.5	59,822.5	62,000.0	104,880.0
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян төг	30,800.8	31,667.4	24,062.6	30,539.5
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян төг	20,500.2	30,590.5	21,562.6	913.7
	а/Орлогын татварт	мян төг	10,500.0	1,076.9	2,500.0	4,611.9
	б/НӨТ	мян.төг	15,550.0	25,972.1	17,700.0	17,555.0
	в/НДШ	мян.төг	11,925.8	11,925.7	11,712.0	99,730.0
	г/Хүн амын орлогын татвар	мян төг	4,800.0	4,800.0	5,000.0	5,585.0
	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян төг	-	-	500.0	500.0
	ё/Тээврийн хэрэгслийн татвар	мян төг	250.0	150.0	250.0	250.0
	ж/Бусад татвар	мян төг	4,500.0	4,335.0	3,500.0	2,000.0
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	12.0	12.0	12.0	14.0
9	Нийт цалингийн сан	мян төг	78,928.3	79,604.3	86,755.7	86,722.1
10	Нэг ажилтны дундаж цалин	мян төг	548.1		602.4	516.2
12	Хөрөнгө оруулалт	мян төг	16,500.0	15,000.0	15,000.0	
13	Нийт авлага	мян төг	81,860.4	102,438.0	50,000.0	41,178.2
14	Нийт өглөг	мян төг	8,121,134.0	1,358,298.8	1,358,200.8	2,050,954.8
	Богино хугацаат ер төлбөр					16,752.3
	Урьдчилж орсон орлого	мян төг				2,034,202.5

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын зорилго нь "Сумын дулаан хэрэглэгчдийн ажиллах, сурч, амьдрах таатай орчныг хангах"-д оршино. ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгжийн байр, иргэдийн сууцыг дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлнэ" гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заасны дагуу чиг үүргийн давхардалгүй, захирал, нягтлан бодогч, нярав, механикч, засварчин, 8 галч, нийт 13 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Удирдлагын цалин хөлсийг 932.6 мянган төгрөгөөр тогтоосон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь Сүхбаатар сумын албан байгууллага, айл өрхийг дулаанаар хангах үндсэн үйл үйл ажиллагаагаа дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулдаг байна. Сүхбаатар аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/21 дүгээр тогтоолоор тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатайгаар сунгасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт орсон бөгөөд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр үр нөлөө дунд байна гэж үзсэн. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн хувьд мөнгөн гүйлгээний тайланг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй

бүртгэлээс ерөнхий журналд бичилт хийгддэггүй, гараас бичилт хийдэг, үндсэн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийхэд хүндрэлтэй зэрэг алдаа, дутагдалтай байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайлааст голомт ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хайлааст голомт ОНӨААТҮГ -ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хайлааст голомт ОНӨААТҮГ -ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,412.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	78,456.5	71,947.4	-6,509.1
Авлага	99,383.8	41,178.2	-58,205.5
Бараа материал	17,798.8	62,632.8	44,833.9
Үндсэн хөрөнгө	1,642,673.5	1,614,057.5	-28,615.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,838,312.9</b>	<b>1,789,900.4</b>	<b>-48,412.4</b>
Өр төлбөр	36,937.0	16,752.3	-20,184.7
Бусад урьдчилж орсон орлого	1,287,238.9	1,256,418.6	-30,820.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	514,136.8	516,729.5	2,592.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,838,312.9</b>	<b>1,789,900.4</b>	<b>-48,412.4</b>

Кассад бэлэн мөнгөний үлдэгдэлгүй байна. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 21,047.4 мянган төгрөг, хугацаатай хадгаламж 50,000.0 мянган төгрөг, ахмадын сангийн харилцах дансанд 900.0 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд борлуулалтын авлага 15,189.0 мянган төгрөг, ААНОАТ-ын авлага 3,606.4 мянган төгрөг, бусад авлага 22,382.8 мянган төгрөгийг эзэлж байна.

ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн программ нь авлагын үлдэгдлийн хугацаа, насжилтыг тооцдоггүй байна. Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 62,632.8 мянган төгрөг болж 44,833.9 мянган төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд: шинээр 3,180.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч нэмэгдэж, элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 16,752.3 мянган төгрөгийн өр төлбөр байна. Мөн 1,256,418.6 төгрөгийн өр төлбөр нь үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар сумын ИТХ-ын 2021 оны А/61 дүгээр тогтоолоор Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 286,318.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 264,756.0 мянган төгрөгөөр, 21562.8 мянган төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 15,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. Сүхбаатар сумын ИТХ-ын 2022 оны 3-А/12 дугаар тушаалаар Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 27,000.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 395,509.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 392,455.6 мянган төгрөгийн зардал гарган, 3,053.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 395,509.5 мянган төгрөг болж төлөвлөснөөс 82190.7 мянган төгрөг буюу 26.2 хувиар давсан байна. Үүнд үнэ төлбөргүй шилжин ирсэн үндсэн хөрөнгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж, улмаар тухайн хөрөнгийн тайлант үеийн элэгдлийн зардалтай тэнцэх хэмжээгээр урьдчилж орсон орлого дансыг бууруулах бичилт хийж, тайлант үеийн бусад орлогоор 114,433.7 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, дулааны хэрэглэгч нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 392,455.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 100,699.6 мянган төгрөг буюу 34.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь байгууллагын үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотойгоор элэгдлийн зардлын өсөлт зэрэг нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу машины гарш барих, хөрөнгө худалдан авахад өөрийн эх үүсвэрээс 18,500.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 2,592.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,593.0 мянган төгрөгөөр буурч байгаа Нүүрс тээврийн хөлсийг 1тн/км-ийг 2022 оны 10 сараас 262 төгрөгөөр тооцох нормативтай байтал 390 төгрөгөөр тооцож олгосон 20, 2020 онд гэрээ байгуулж, үүргийн биелэлтийг дүгнэн ашигтай ажиллуулсан нөхцөлд ашгийн 30 хувь буюу 10,040.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь нөлөөлж байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ -ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлаас 288,024.5 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 5,760.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1<sup>1</sup>-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд гэрэл цахилгааны зардал 4,677.1 мянга, нүүрс нүүрс тээврийн хөлс 19,956.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>2</sup> заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	1,100.0	1	0	
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>1,100.0</b>	<b>1</b>	<b>0</b>	

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг алдаатай илэрхийлдэг, үндсэн хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журнал уялдаагүй, ерөнхий журнал дахь дебет, кредит ажил гүйлгээний дансны дугаар харагддаггүй, авлагын хугацаа, насжилтыг тооцоолдоггүй зэрэг алдаа, дутагдалтай байна. Иймд санхүүгийн шинэ программ хангамжтай болох зөвлөмж хүргүүлсэн биелээгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 124,377.9 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 124,377.9 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нийт 6 алдаа зөрчил илэрснээс зөрчил дахин давтан гаргахгүй байх 4 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

### 5.1 Албан шаардлага

**5.1.1** Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг алдаатай илэрхийлдэг, үндсэн

<sup>2</sup> Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ер, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журнал уялдаагүй, ерөнхий журнал дахь дебет, кредит ажил гүйлгээний дансны дугаар харагддаггүй, авлагын хугацаа, насжилтыг тооцоолдоггүй зэрэг алдаа, дутагдалтай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4/нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах/ заалттай нийцэхгүйд албан шаардлага хүргүүлэв.

**5.1.2** Өмнөх онуудад үүсэж, санхүүгийн тайланд олон жил илэрхийлэгдсэн авлага 27,363.8 мянга, өр төлбөр 3,498.8 мянга нийт 30,862.6 мянган төгрөгийг барагдуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5./дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх/ заалттай нийцэхгүй байгаад албан шаардлага хүргүүлэв.

**5.1.3** Нүүрс тээврийн хөлсийг 1тн/км-ийг 2022 оны 10 сараас 262 төгрөгөөр тооцох нормативтай байтал 390 төгрөгөөр тооцож, нэмэгдүүлэн зөрүү 20,379.8 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 /үр ашигтай байх/, 4.2.1 /зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах/, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 тоот тушаалын хоёрдугаар хавсралтыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлэв.

**5.1.4** Сумын засаг дарга Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын захиралтай 2020 онд гэрээ байгуулж, үүргийн биелэлтийг дүгнэн ашигтай ажиллуулсан нөхцөлд ашгийн 40 хувийн урамшуулал олгохоор заасан. Гэтэл гэрээний биелэлтийг дүгнээгүй, дүгнэх шалгуур үзүүлэлт хангалтгүй, 2021 оны санхүүгийн тайлангаар эдийн засгийн үзүүлэлтээр 98,482.0 мянган төгрөгийн авлага, 36,591.9 мянган төгрөг өр төлбөртэй байхад цэвэр ашгийн 30 хувиар буюу 10,040.1 мянган төгрөгийн урамшуулал олгожээ. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 /үр ашигтай байх/, 4.2.1 /зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах/, 15.2.5 /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх/, Аймгийн ИТХ-ын 2019 оны 49 дугаар тогтоолыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлэв.

## **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.2.1 Шилэн данстай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, мөрдөж ажиллах.

## 5.2.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1<sup>4</sup>, 72.4.2<sup>5</sup>, 72.4.4<sup>6</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>7</sup> дахь заалттай нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд "Зээл өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө" -д 124377.9 мянган төгрөгийг зардлыг давхардуулан бүртгэсэн байна.	1	124377.9			1	124377.9	1	124377.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>124377.9</b>			<b>1</b>	<b>124377.9</b>	<b>1</b>	<b>124377.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
санхүүгийн программын хувьд мөнгөн гүйлгээн тайлангийн санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн	1	0			1	0						

<sup>4</sup> эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;

<sup>5</sup> тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих;

<sup>6</sup> комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;

<sup>7</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

гүйлгээг алдаатай илэрхийлдэг.										
Өмнөх онуудад үүсэж, санхүүгийн тайланд олон жил илэрхийлэгдсэн авлага 27,363.8 мянга, өр төлбөр 3,498.8 мянга нийт 30,862.6 мянган төгрөгийг барагдуулаагүй	1	30862.6		1	30862.6					
Нүүрс тээврийн хөлсийг 1тн/км-ийг 2022 оны 10 сараас 262 төгрөгөөр тооцох нормативтай байтал 390 төгрөгөөр тооцож, нэмэгдүүлэн зөрүү 20,379.8 мянган төгрөг илүү олгосон	1	20379.8		1	20379.8					
Гэтэл гэрээний биелэлтийг дүгнээгүй, дүгнэх шалгуур үзүүлэлт хангалтгүй байхад урамшуулал олгосон	1	10040.1		1	10040.1					
Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй.	1	0				1	0			
Дүн	5	61282.5		4	61282.5		1	0		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 142 мэдээллээс 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	0
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								